Засгийн газрын 2019 оны 65 дугаар тогтоолоор тус яамны орон тоог 147 байхаар баталснаас гадаад харилцааны яам нь 2021 оны жилийн эцсийн байдлаар улс төрийн албан тушаалтан 2, төрийн тусгай албан хаагч /дипломат ажилтан/ 113, төрийн захиргааны албан хаагч 15, төрийн үйлчилгээний албан хаагч 14, нийт 147 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль Монгол Улсын Их Хурлаар 2021 оны 6 дугаар сарын 11-нд батлагдаж, 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлсэн;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Гадаад харилцааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь төсвийн захирагчийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Гадаад харилцааны яамны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 1.0 хувиар буюу 133,066.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Гадаад харилцааны яамны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 239,383.7 мянган төгрөгөөр буюу 2.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, өглөг, урьдчилж гарсан зардал, бараа материалын данснуудад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	4,246.2	4,246.2	-
Авлага	283,882.0	63,964.7	(219,917.3)
Урьдчилж гарсан зардал	18,980.0	6,650.0	(12,330.0)
Бараа материал	332,135.8	305,954.7	(26,181.1)
Үндсэн хөрөнгө	10,278,976.2	10,298,020.9	19,044.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>10,918,220.3</b>	<b>10,678,836.5</b>	<b>(239,383.8)</b>
Богино хугацаат өр төлбөр	29,277.2	8,697.5	(20,579.7)
Цэвэр хөрөнгийн дүн	10,888,943.1	10,670,139.0	(218,804.1)
<b>Өр төлбөр, цэвэр хөрөнгийн дүн</b>	<b>10,918,220.3</b>	<b>10,678,836.5</b>	<b>(239,383.7)</b>

Дансны үлдэгдэл гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Авлагын үлдэгдэл 219,917.3 мянган төгрөгөөр буурсан нь нэмэлт санхүүжилтийн харилцах дансны 163,942.9 мянган төгрөгийн үлдэгдлээс 165 иргэнд тусгаарлах байрны зардалд 120,232.9 мянган төгрөгийг зарцуулж, Сангийн яаманд татан төвлөрүүлсэн 42,839.9 мянган төгрөгөөр тооцоо нийлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн;
- Өглөг дансны үлдэгдэл 20,579.6 мянган төгрөгөөр буурсан нь харилцагч байгууллага, хувь хүмүүстэй томилолт, дараа тайлангийн тооцоо хийж, холбогдох тушаал шийдвэрт үндэслэн өглөгийг хаасан;
- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл 12,330.0 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх онуудад Ай Ти Зон ХХК-аас худалдан авсан лицензийн төлбөрийг хаасан;
- Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 19,044.7 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн санхүүгийн удирдлагын ил тод, үр ашигтай байдал төслөөс 2021 оны 12 сарын 01-ний өдрийн 01/316 тоот албан бичгийн дагуу 17,655.5 мянган төгрөгийн компьютер техник хэрэгслийг үнэ төлбөргүй хүлээн авсан, тайлант онд тоног төхөөрөмж 30,318.8 мянга, программ хангамж 974,630.7 мянган төгрөгөөр тус тус худалдан авсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд санхүүжилтийн эх үүсвэрийг 38,801,659.4 мянган төгрөг, үүнээс урсгал зардалд 38,801,659.4 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 25,944,072.1 мянган төгрөгөөр бууруулан, нийт зарлага ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 12,857,587.4 мянган төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 112,200.0 мянган төгрөгөөр бууруулан санхүүжилтийн эх үүсвэрийг 12,745,387.3 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 12,745,387.3 мянган төгрөгийн төсөв батлуулснаас төсөвт байгууллагын өөрийн орлогоос 1,550,000.0 мянга, 11,195,387.3 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөсөн, гүйцэтгэлээр үйл ажиллагааны орлогоос 476,179.7 мянга, улсын төсвөөс 8,745,654.8 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 9,221,834.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 8,002,183.5 мянган төгрөгийг зарцуулж, улсын төсөвт тэмдэгтийн хураамжийн орлогот 389,044.5 мянга, үлдэгдэл 830,606.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 8,002,183.5 мянган төгрөг буюу 62.8 хувьтай байгаа нь байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 189,847.7 мянга, томилолт зочны зардлыг 506,578.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 314,029.3 мянга, засгийн газрын гадаад шилжүүлэг 1,769,134.4 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
	Код	Нэр				
<b>Гадаад харилцааны бодлого удирдлага /70305/</b>						
1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	6,793,547,800.0	5,884,050,739.6	909,497,060.4	86.6
		Үйл ажиллагааны урсгал зардал	6,793,547,800.0	5,884,050,739.6	909,497,060.4	86.6
2	80215	Эрдэм шинжилгээ судалгааны ажил	192,460,000.0	87,633,000.0	104,827,000.0	45.5
		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	192,460,000.0	87,633,000.0	104,827,000.0	45.5
3	80218	Улс орноо гадаадад сурталчлах	242,550,000.0	74,100,610.0	168,449,390.0	30.6
		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	242,550,000.0	74,100,610.0	168,449,390.0	30.6
4	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	203,429,300.0	158,662,175.8	44,767,124.2	78.0
		Бараа үйлчилгээний бусад зардал	203,429,300.0	158,662,175.8	44,767,124.2	78.0
5	80509	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,471,325,800.0	1,721,867,800.0	1,749,458,000.0	49.6
		ОУ-ын байг-ын гишүүнчлэлийн хураамж	3,471,325,800.0	1,721,867,800.0	1,749,458,000.0	49.6
6	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	316,270,500.0	68,842,610.0	247,427,890.0	21.8
		Тэтгэвэрт гарахад	287,202,000.0	42,155,410.0	245,046,590.0	14.7
		Нэг удаагийн тэтгэмж	29,068,500.0	26,687,200.0	2,381,300.0	91.8
7	81520	Олон улсын хурал зөвлөгөөн	236,544,500.0	-	236,544,500.0	-
		Бараа үйлчилгээний бусад зардал	236,544,500.0	-	236,544,500.0	-
8	82905	Засгийн газар хоорондын комисс	291,892,100.0	26,702,969.8	265,189,130.2	9.1
		Бараа үйлчилгээний бусад зардал	291,892,100.0	26,702,969.8	265,189,130.2	9.1
9	82907	Бүс ба зам санаачилга	7,367,300.0	-	7,367,300.0	-
		Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,367,300.0	-	7,367,300.0	-
<b>Олон улсын хамтын ажиллагааг дэмжих /70303/</b>						
10	82908	Олон улсын хамтын ажиллагааг дэмжих	990,000,000.0	-	990,000,000.0	-
		Бараа үйлчилгээний бусад зардал	990,000,000.0	-	990,000,000.0	-

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гадаад харилцааны яам нь 2021 онд урьд оны үлдэгдэл хандив тусламжийн орлогоос 163,072.9 мянга, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 3,732,715.6 мянга, дээд шатны төсийн захирагчаас 87,633.0 мянга, өөрийн үйл ажиллагааны нэмэлт орлогоос 159,377.2 мянга, нийт 4,142,798.7 мянган төгрөгийн орлого бүрдүүлж үүнээс 4,052,989.8 мянган төгрөгийг хөтөлбөр арга хэмжээнд зарцуулж, 89,808.9 мянган төгрөгийг Сангийн яамны төрийн санд төвлөрүүлж, 42,839.9 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд хөтөлбөр арга хэмжээ, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 2 хөтөлбөр, 10 арга хэмжээний хэрэгжилт 86.2 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 62.8 хувийн биелэлттэй байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны 764,760.8 мянган төгрөгийн орлогоос дараах зарцуулалтуудыг гаргасан байна. Тухайлбал:

- Засгийн газрын 2021 оны 10 дугаар сарын 20-ны 322 дугаар тогтоолоор ЗГНС-аас Ардын хувьсгалын 100, Монгол улс НҮБ-д элссэний 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх 320,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч 318,853.6 мянган төгрөгийг зарцуулсан;
- Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 371 тоот тогтоолоор ЗГНС-аас МУЕ-ийн ОХУ-д албан ёсны айлчлал хийхэд 344,760.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 344,669.8 мянган төгрөгийг зарцуулсан;
- Соёлын сайдын А/50 тоот эрх шилжүүлэх тушаалаар НҮБ-ын 60 жилийн ой тэмдэглэн өнгөрүүлэх цогц арга хэмжээний санхүүжилтэд 100,000.0 мянган төгрөг авч 98,651.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад АОУС 701.8-д тодорхойлсон үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд гараагүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс 180 мэдээллийг хугацаандаа байршуулсан боловч 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын 982,455.5 мянган төгрөгийн 6 ажил гүйлгээг цахим хуудсанд байршуулаагүй байна.



Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 “энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага дараах мэдээллийг долоо хонгийн дотор мэдээлнэ”; 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” байршуулна гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлангийн эрх үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Гадаад харилцааны яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгдээгүй.

Өмнөх аудитаар өгсөн 2 албан шаардлагын хэрэгжилт 80.0, 3 зөвлөмжийн хэрэгжилт 50.0 хувьтай байна.

*Хүснэгт-4* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		Хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	2	145,435.3	1	-	1	145,435.3	80.0
Зөвлөмж	3	1,603,529.7	2	1,151,054.9	1	452,474.8	50.0
Нийт дүн	5	1,748,965.0	3	1,151,054.9	2	597,910.1	-

Өмнөх аудитаар өгсөн төсвийн орлого бүрдүүлэх зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

ГХЯ нь “ХӨМОТЭ” ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн “Ёслол хүндэтгэлийн өргөө”-ний барилга 2017 онд ашиглалтад орсон боловч, одоогоор дуусаагүй барилга байгууламж дансанд бүртгэлтэй, улсын комисс хүлээн авсан шийдвэр гараагүй, тус компанитай шүүхийн маргаантай асуудлыг дараагийн аудитаар авч үзнэ.

#### **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 28,250.2 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 16,824.2 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 11,426.0 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй нийт 11,426.0 мянган төгрөгийг алдаа, зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшин 99,678.3 мянган төгрөгөөс бага тул Зөрчилгүй дүгнэлт өгсөн.

##### **4.1 Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Эзэн холбогдогч нь тодорхойгүй, олон жил болсон авлага, өглөгийг ажлын хэсэг байгуулан ажиллаж, эрх зүйн шийдвэргүйгээр данснаас хасч өмнөх үеийн үр дүнд хаасныг залруулж санхүүгийн тайланд авлагаар тусгуулж, баталгаажуулав.

##### **4.2 Албан шаардлага**

###### **1. Илрүүлэлт:**

1.Тайлант онд 9,952.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, цалингаас тооцох ХХОАТ, НДШ-ийг буруу тооцсоноос 924.7 мянган төгрөгийн НДШ-ийн авлага, 548.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэнтэй нийцэхгүй, эрх үүрэг ба үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, нэмж үүсгэхгүй байх албан шаардлага өгөх.

###### **2. Илрүүлэлт:**

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг дутуу бүрдүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өгсөн зөвлөмж хэрэгжүүлэн ажиллаж байх, төсвийн орлогыг бодитой төлөвлөн, биелэлтийг хангаж ажиллах албан шаардлага өгөх

##### **4.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### **1. Нийцэлтэй холбоотой асуудал**

###### **Илрүүлэлт:**

Тайлант онд Бүгд найрамдах Энэтхэг улсад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх тухай Засгийн газрын 111 дүгээр тогтоолоор ЗГНС-аас 2,850,260.0 мянган төгрөгийг тус яамны нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн боловч төсөв захирагчийн холбогдох тушаал шийдвэр гараагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.38-д "төсвийн шууд захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг

тайлагнах эрх бүхий этгээдийг"; 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсөв зарцуулахдаа тухай бүрт нь төсөв захирагчийн тушаал гаргаж байх, анхан шатны бүрдэл хангасан баримтаар ажил гүйлгээг хийж, бүртгэлд тусгаж байх;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 51/А0170076

Улаанбаатар хот

АХП-2022/113/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Гадаад харилцааны яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 9,952,482,00 төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, цалингаас тооцох ХХОАТ, НДШ-ийг буруу тооцооноос 924,784.41 төгрөгийн НДШ-ийн авлага, 548,689.31 төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүссэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах," гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, барагдуулж ажиллах, нэмж үүсгэхгүй байх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа, нягтлан бодогч С.Алтангэрэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
С.ОТГОНХОРЛОО



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 52/АО 170076  
АХТ - 2022/119/НА - СТН - ТШС  
Зөрчил арилгуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Гадаад харилцааны яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тулган баталгаажуулахад 982,455,583.78 төгрөгийн ажил гүйлгээг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага дараах мэдээллийг долоо хонгийн дотор мэдээлнэ"; 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" байршуулна" гэж заасныг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1 заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж, цалингаас бусад орлого, зарлагын мөнгөн гүйлгээг иж бүрэн мэдээлэх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа, Нягтлан бодогч С.Алтангэрэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
С.ОТГОНХОРЛОО



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 68/А0170076

Улаанбаатар хот

АХГ-2022/119/НА-СТА-ТШС  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 заалтын дагуу Гадаад харилцааны яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуулиар баталсан төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг дутуу бүрдүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах, төсвийн орлогыг бодитой төлөвлөх, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гарахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр, Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга Х.Алтантуяа, нягтлан бодогч С.Алтангэрэл нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ  
С.ОТГОНХОРЛОО

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Гадаад харилцааны яамны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын алдаа, зөрчил

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	тоо	дүн	тоо	дүн	Тоо	дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар																
1	Гадаад харилцааны яам	АХГ-2022/119/Н А-СТА-ТШЗ	Авлага, өр төлбөрийн данстай холбоотой асуудал	Томилолтын дараа тооцоог хугацаанд нь хийгээгүйгээс эзэн холбогдогч нь тодорхойгүй, олон жил болсон авлага, өглөгийг ажлын хэсэг байгуулан ажиллаж, эрх зүйн шийдвэргүйгээр данснаас хасч өмнөх үеийн үр дүнд хаасан.	1	16,824.2	1	16,824.2								
2	Гадаад харилцааны яам	АХГ-2022/119/Н А-СТА-ТШЗ	Авлага, өр төлбөртэй холбоотой асуудал	Тайлант онд 9,952.5 мянган төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, цалингаас тооцох ХХОАТ, НДШ-ийг буруу тооцсоноос 924.7 мянган төгрөгийн НДШ-ийн авлага, 548.6 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг үүссэн байна.	1	11,426.0					1	11,426.0				
3	Гадаад харилцааны яам	АХГ-2022/119/Н А-СТА-ТШЗ	Нийцэлтэй холбоотой асуудал	ЗГНС-гаас Засгийн газрын 111 дүгээр тогтоолоор Бүгд найрамдах Энэтхэг улсад хүмүүнлэгийн тусламж үзүүлэх тухай 2,850,260.0 мянган төгрөгийг тус яамны нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн боловч төсөв захирагчийн холбогдох тушаал шийдвэр гараагүй байна.	1	-								1	-	
4	Гадаад харилцааны яам	АХГ-2022/119/Н А-СТА-ТШЗ	Төсвийн орлоготой холбоотой асуудал	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулиар батлагдсан төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг дутуу төвлөрүүлсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.	1	-					1	-				
Дүн					4	28,250.2	1	16,824.2	-	-	2	11,426.0	-	-	1	-
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал																
5	Гадаад харилцааны яам	АХГ-2022/119/Н А-СТА-ТШЗ	Шилэн дансны мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулаагүй байх	Шилэн дансны цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, үйлчилгээ болон цалингийн зардлаас бусад орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тулган баталгаажуулахад 982,455.5 мянган төгрөгийн ажил гүйлгээг байршуулаагүй байна.	1	982,455.5					1	982,455.5				
Дүн					1	982,455.5	-	-	-	-	1	982,455.5	-	-	1	-
Нийт дүн					5	1,010,705.7	1	16,824.2	-	-	2	993,881.5	-	-	1	-





